



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ЗАНДААХҮҮГИЙН ЭНХБОЛД
ТАНАА

2015.04.23 № 786
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А. ЗАНГАД



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН
ТАЙЛАН**

*Улсын Их Хурлын даргын төсвийн 2014 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2014/01/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот

2015 оны 4 дүгээр сар



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын
газрын дарга С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 260512
Цахим хаяг:
ouungerels@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Юра
Утас: 263813
yurag@audit.gov.mn

Монгол Улсын
Үндэсний аудитын газар
Улаанбаатар-15160
Бага тойруу 3
Засгийн газрын IV байр
Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
Байгууллагын хууль, эрх зүйн орчин
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй,
хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон
нарийвчилсан горим, түүний үр дүн
Дотоод хяналт
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар
Шилэн дансны мэдээлэл
Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
Гол, онцлог гүйлгээний талаар
Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар
Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын
талаарх тайлбар
Анхаарал татахуйц бусад чухал асуудал
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн
зөрчлийн нэгтгэл
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Зөвлөмж
Аудитын гэрчилгээний тохирох загварын талаар
санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 3: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2015 оны 4 дүгээр сар

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /УАГ-САГ/2015/01-СТА-ТЕЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 05-наас 2015 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын ахлах аудитор Г.Юра хэрэгжүүлэв.

2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2015 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 14/659 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Улсын Их Хурлын Тамгын газар нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал"-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Аудитын явцад төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Улсын Их Хурлын Тамгын газрын дүрмийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т заасны дагуу Улсын Их Хурлаас 2006 онд баталсан бөгөөд, Улсын Их Хурлаас хууль тогтоох, төрийн бодлого тодорхойлох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд

нь зөвлөгөө, туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий бие даасан, мэргэшсэн, төрийн захиргааны байгууллага юм.

Улсын Их Хурлын Тамгын газар нь Улсын Их Хурал, түүний гишүүд, Байнгын болон дэд, түр хороодын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, тэдгээрийг ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүрэгтэй, үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Тамгын газрын дүрэм болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон ажиллаж байна. Тус газар нь 2014 онд 23,418.8 сая төгрөгийн тодотгосон төсөвтэй, 607 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж иржээ.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 11 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны тодотгосон төсвийн нийт зардлын 1 хувиар тооцож 234.2 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В-1/

УИХ-ын Тамгын газрын ЕНБД-ын 2013 оны 364 тоот захирамжаар батлагдсан “Санхүүгийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тайлант хугацаанд УИХ-ын Тамгын газар санхүүгийн бүртгэлээ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл бүхий санхүү, нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програмаар хөтөлж, санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналтын талаар

УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 111 дүгээр захирамжаар дотоод аудитыг 1 орон тоотойгоор төсвийн шууд захирагчийн удирдлагад ажиллуулж байна.

Дотоод аудитор нь төсвийн шууд захирагчийн бүрэн эрхийн хүрээнд байгууллагын төсөв болон гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавин Тамгын газрын төсөв, санхүүгийн үйл

ажиллагаанд явцын хяналт болон бие даасан аудитыг хийж, эрсдэлийг тодорхойлж, үнэлэхэд удирдлагад туслах зорилготойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Дотоод аудитаар Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны төсөв боловсруулалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, 2013 оны жилийн эцэс, 2014 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудит хийж нийт 26 зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Түүнчлэн УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 176 тоот захирамжаар байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулж байна.

Зөвлөл нь УИХ-ын Тамгын газрын өмч хөрөнгийн асуудлаар санал дүгнэлт гаргаж холбогдох материалыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг тооцох, тайлагнах ажлыг удирдан зохион байгуулах үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар

Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны төсвийг 90 нэгжээр 26,133.5 сая төгрөгөөр баталснаас төсвийн тодотголоор 3,214.7 сая төгрөг *лүүнээс хөрөнгө оруулалтын төсвөөс 2,000.0 сая төгрөг хасагдаж, 240.0 сая төгрөгийг урсгал төсөвт шилжүүлсэн*-өөр буурч, 22,918.8 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 18,515.3 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 19.2 хувиар буюу 4,402.5 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Нэгжийн			Батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Биелэлт	
Нэр	тоо	хэтрэлт/+, хэмнэлт/-				хувь	
Улсын Их Хурлын гишүүн	76	13,015.7	12,827.5	11,623.8	(1,203.7)	90.6	
Байнгын хороо	8	400.0	400.0	400.0	-	100.0	
УИХ-ын нийтлэг	1	6,250.0	3,629.8	1,567.9	(2,061.9)	43.2	
Үүнээс: хөрөнгө оруулалт		2,740.0	500.0	-	(500.0)		
Нам эвслийн бүлэг	3	805.6	823.6	764.7	(58.9)	92.8	
Тамгын газар	1	5,456.2	5,526.6	3,951.8	(1,574.8)	71.5	
УИХ-ын даргын ажлын алба	1	206.0	211.3	207.1	(4.2)	98.0	
Нийт дүн	90	26,133.5	22,918.8	18,515.3	(4,403.5)	80.8	

УИХ-ын Тамгын газар “Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолыг хэрэгжүүлж зарим зардлыг хэмнэх бодлого баримталж ажилласнаар батлагдсан төсвийг 19.2 хувиар буюу 4,402.5 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

Тухайлбал, хангамж бараа материалын зардлаас 0.5 тэрбум төгрөг, гадаад, дотоод томиллолт, зочны зардлаас 1.6 тэрбум төгрөг, мэдээлэл сурталчилгааны болон судалгаа шинжилгээ зэрэг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 1.4 тэрбум төгрөг

хэмнэсэн байна.

Хөрөнгө оруулалтын зардалд тодотгосон төсвөөр 500.0 сая төгрөг батлагдсан боловч зарцуулалт хийгдээгүй байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Улс, орон нутгийн төсөв, хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод нээлттэй, ойлгомжтой байлгах, түүнд олон нийт хяналт тавих, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилт бүхий “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийн хүрээнд УИХ-ын Тамгын газар нь холбогдох мэдээллийг тухай бүр цахим системд оруулж байна.

Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д заасны дагуу shilendans.gov.mn цахим хуудсанд 2015 оны эхний улирлын байдлаар дараах 88 мэдээллийг оруулсан байна. Үүнд:

Мэдээллийн нэр төрөл	Оруулсан мэдээний тоо
Төсвийн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт, гүйцэтгэл	1
Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт	2
Цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ	79
Шийдвэрийн жагсаалт	7
Төслийн орлого	1

Түүнчлэн УИХ-ын Тамгын газар шилэн дансны нэгдсэн системд хамаарахгүй 2015 оны жилийн төсвийн сарын хуваарь, урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө зэрэг мэдээллийг өөрийн parliament.gov.mn цахим хуудсанд оруулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу тогтоосон эрсдэл, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэсэн болно.

Гол, онцлог гүйлгээний талаар

Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүн бүхий дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

2014 онд УИХ-ын Тамгын газарт БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОИКА/-тай хамтран “Цахим парламент” төсөл хэрэгжүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааны цахим системийг иж бүрэн шинэчлэх төслийн хүрээнд хуралдааны танхимуудын програм хангамж, дуу, дүрсийн дэд системүүдийг иж бүрэн шинэчилсэн. Мөн парламентын сэтгүүлчдийн, техникийн удирдлагын болон мэдээллийн төвийн өрөө тасалгааг шинээр байгуулан орчин үеийн өндөр үзүүлэлт бүхий тоон системийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглож, нийт 100 гаруй нэр төрлийн 3,730.8 сая төгрөгийн үнэ бүхий техник хэрэгсэл,

сэлбэг материал болон дагалдах ажлын багажуудыг бүртгэлд тусган тайлагнасан байна.

Тамгын газрын ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэн, 2014 онд 21 ажилтанд орон сууцны нөхцөл сайжруулахад нийт 240.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

2014 онд УИХ-ын батлагдсан төсөв өмнөх оноос 7.0 тэрбум төгрөгөөр, гүйцэтгэл 4.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь УИХ-ын сонгуулийн тойргоос сонгогдсон гишүүн бүрийн өөрийн төсөвт зардалд "Тойрогт ажиллах зардал"-ыг тус бүр 90.0 сая төгрөгөөр тооцон төсөвлөснөөр нийт 4.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсантай холбоотой байна.

Аудитаар илрүүлсэн гол зүйлс, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад УИХ-ын Тамгын газарт мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлан гаргалтын талаар:

Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан журам, аргачлалын дагуу бэлтгэж тайлагнасан байна.

2014 оны санхүүгийн тайлангаар 4.0 сая төгрөгийн авлага, 10.9 сая төгрөгийн урьдчилж төлсөн төлбөр, 1.1 сая төгрөгийн өглөг, 1,214.3 сая төгрөгийн бараа материал, 6,504.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг хийж, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Бараа материалын талаар:

Бараа материал оны эхэнд 631.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол тайлант хугацаанд 1,139.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэн нийлүүлж, БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн "Цахим парламент" төслөөс 57.5 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл хүлээн авч, албан хэрэгцээнд шаардах хуудсаар 456.6 сая төгрөгийн бараа материал зарцуулж, ТӨХ-ны 2014 оны 480 дугаар тогтоол, УИХ-ын Тамгын газрын ЕНБД-ын 2014 оны 504 дүгээр захирамжаар 99.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Төрийн тусгай хамгаалалтын газарт балансаас балансад шилжүүлж, оны эцэст 1,214.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оноос 582.5 сая төгрөг буюу 92.2 хувиар өссөн байна.

Нийт бараа материалын 14.8 хувийг сэлбэг хэрэгсэл, 19.3 хувийг бэлэг, дурсгалын зүйл, 8.5 хувийг аж ахуйн материал, 38.1 хувийг БҮТЭЗүйл, 11.2 хувийг бичиг хэргийн материал, 8.1 хувийг бусад бараа материал эзэлж байна.

2014 оны төсвийн жилд УИХ-ын даргаас өгсөн чиглэл, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэдэх Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ЕНБДаргын 2014 оны 667 тоот захирамжаар шинээр байгуулагдсан "УИХ-ын Тамгын газрын Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төв"-ийг ажиллуулахад шаардлагатай 77.6 сая төгрөгийн тавилга эд хогшил,

“Бялдаржуулах танхим”-д 49.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, УИХ-ын дарга, гишүүдийн ажиллах хэвийн үйл ажиллагааг хангах, чуулган, Байнгын хороодын тасралтгүй үйл ажиллагааг хангах үүднээс 202.2 сая төгрөгийн тавилга, эд хогшил зэрэг хөрөнгийг бэлтгэн нийлүүлсэн байна.

УИХ-ын Тамгын газар бараа материалын дансанд бүртгэлтэй 78 нэрийн 422.7 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд шилжүүлж бүртгэх, ашиглалтын хугацаа дууссан 63 нэрийн 133.3 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн данснаас хасах хүсэлтийг 2015 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 14/473 дугаар албан бичгээр Төрийн өмчийн хороонд хүргүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

Үндсэн хөрөнгө оны эхэнд 4,143.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байснаас тайлант хугацаанд БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн “Цахим парламент” төслөөс 3,663.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгасан, Төрийн өмчийн хорооны 2014 оны 16/520, 3/464 дугаар албан бичиг, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн УИХ-ын Тамгын газрын ЕНБД-ын 2014 оны 131 дүгээр захирамжаар ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 91 нэрийн 172.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан, балансаас балансад 6.0 сая төгрөгийн хөрөнгийг ЗГХЭГ-т шилжүүлж, ЗГХЭГ-аас 11.5 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

Мөн Төрийн өмчийн хорооны 2014 оны 480 дугаар тогтоолыг үндэслэн УИХ-ын Тамгын газрын ЕНБД-ын 2014 оны 504 дүгээр захирамжаар үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 58.0 сая төгрөгийн үнэ бүхий орчуулгын тоног төхөөрөмжийг Тагнуулын ерөнхий газарт, 27.0 сая төгрөгийн үнэ бүхий уран зургийг Төрийн түүхийн музейд тус тус балансаас балансад шилжүүлж, оны эцэст 6,504.1 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий үндсэн хөрөнгөтэйгээр тайлагнасан байна.

Орлогын талаар:

УИХ-ын Тамгын газар 2014 онд урсгал төсвийн санхүүжилтийн 18,546.2 сая, төсвийн урамшууллын санхүүжилтийн 129.6 сая, хэвлэх цехийн үйл ажиллагааны орлого 209.1 сая төгрөг, мөн Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОИКА/-аас хүлээн авсан 3,730.8 сая төгрөгийн хөрөнгийг тус тус орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэлд тусган тайлагнасан байна.

Зардлын талаар:

УИХ-ын Тамгын газар “Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” УИХ-ын 2008 оны 28 дугаар тогтоолын дагуу гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай зардлыг төсөвлөн батлуулж, батлагдсан төсвийн дагуу зарцуулж тайлагнасан байна.

УИХ-ын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6-д “Гишүүний төсвийг Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу Тамгын газар зарцуулах бөгөөд зарцуулалтад Төрийн байгуулалтын байнгын хороо хяналт тавина” гэж заасны дагуу УИХ-ын Тамгын газар УИХ-ын тухайн гишүүний албан бичгээр ирүүлсэн зөвшөөрөл *Төрийн төсөвт зардлыг хэрхэн зарцуулах тухай*-ийг үндэслэн гүйцэтгэлийг ханган ажилласан байна.

УИХ-ын Тамгын газрын 2014 оны үйл ажиллагааны тайланг УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны 2015 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн байна.

Тайлант оны эцэст санхүүжилтийн үлдэгдэл 30.9 сая, урьд оны авлага 38.8 сая, 2015 оны Төрийн мэдээлэл сэтгүүлийн төлбөртэй захиалгын орлого 12.1 сая, нийт 81.8 сая

төгрөгийг Төв төрийн санд төвлөрүүлж, Төрийн сангийн газартай хоорондын тооцоогоор баталгаажуулсан бөгөөд “Үлдэгдэл буцаан олгох тухай” Сангийн сайдын 2015 оны 19, 55, 92 дугаар тушаалуудаар баталсан “Зарцуулах эрх нь 2015 төсвийн жилд дамжин хэрэгжих нэмэлт дансны үлдэгдлийг буцаан олгох байгууллагуудын жагсаалт”-д ороогүй тул авлагаар бүртгэж тайлагнаагүй байна.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар санхүүгийн тайланд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Аудитаар илэрсэн бүх асуудлыг УИХ-ын Тамгын газрын удирдлага авч үзэж, судлан шийдвэрлэхээр хүлээн зөвшөөрч, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаар тохиролцсон тул материаллаг алдаагүй гэж үзлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар аудит хийж зөвлөмж өгөөгүй байна.

Зөвлөмж

Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Бид Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланд “зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2015.04.23 № 486
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ЗАНДААХҮҮГИЙН ЭНХБӨЛД
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын Их Хурлын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А. ЗАНГАД

Санхүүгийн аудитын тухай хууль

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,164.27	-
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
Төгрөг\ ЖМС	-	-
Гадаад валют	-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө	10,164.27	-
Төгрөг	-	-
Улсын төсвийн харилцах	-	-
Төсөвт байгууллагын харилцах (Төрийн сан)	10,164.27	-
АВЛАГА	38,822,573.00	3,960,033.00
Ажиллагчидтай холбогдсон авлага		
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	3,960,033.00
Зээлийн хүүгийн авлага		
Бусад авлага	38,822,573.00	-
Байгууллагаас авах авлага	38,822,573.00	-
Гэрэл цахилгааны авлага		
Бусад зардлын тооцооны авлага	38,822,573.00	-
Хувь хүмүүсээс авах авлага		
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	117,978,962.85	10,867,395.50
Бусад урьдчилгаа	98,913,539.00	4,235,000.00
Урьдчилгаа тооцоо	98,913,539.00	4,235,000.00
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	98,913,539.00	4,235,000.00
Томилолтын урьдчилгаа		
Урьдчилж гарсан зардал	19,065,423.85	6,632,395.50
Урьдчилж төлсөн зардал	19,065,423.85	6,632,395.50
БАРАА МАТЕРИАЛ	631,772,822.02	1,214,300,113.50
Түүхий эд материал		
Тусгай зориулалттай материал		
Эм боох материал		
Бэлэн бүтээгдэхүүн		
Хангамжийн материал	631,772,822.02	1,214,300,113.50
Бичиг хэргийн материал	34,538,199.65	136,580,651.22
Аж ахуйн материал	79,024,809.56	102,802,433.84
Сэлбэг хэрэгсэл	207,099,158.72	180,192,542.30
Түлш, шатах тослох материал		
Барилгын засварын материал		
Хүнсний материал		
Баглаа боодол		
Бусад бараа материал	200,670,542.49	560,191,198.89
Мал амьтад		
Бусад	110,440,111.60	234,533,287.25
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	788,584,522.14	1,229,127,542.00
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,143,487,261.22	6,504,144,749.70
Биет хөрөнгө	3,990,991,875.39	6,406,647,209.18
Барилга, байгууламж, орон сууц	33,768,907.33	33,466,507.33
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	36,048,000.00	36,048,000.00
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(2,279,092.67)	(2,581,492.67)
Авто-тээврийн хэрэгсэл		
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг		
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл		

Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,338,048,562.49	1,764,416,226.20
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	3,329,751,764.18	3,099,376,500.46
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(991,703,201.69)	(1,334,960,274.26)
Тавилга, аж ахуйн эд хогшил	592,405,892.76	477,851,288.24
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	1,107,533,216.36	1,080,533,216.36
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(515,127,323.60)	(602,681,928.12)
Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	957,250,529.81	4,042,515,499.11
Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл - Анхны өртөг	2,588,673,589.36	6,251,917,815.83
Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(1,631,423,059.55)	(2,209,402,316.72)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс		
Номын фонд	88,397,688.30	88,397,688.30
Дуусаагүй барилга, байгууламж		
Биет бус хөрөнгө	152,495,385.83	97,497,540.52
Програм хангамж	152,495,385.83	97,497,540.52
Програм хангамж - Анхны өртөг	288,484,369.45	269,208,422.90
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(135,988,983.62)	(171,710,882.38)
Бусад биет бус хөрөнгө		
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг		
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл		
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,932,071,783.36	7,733,272,291.70
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Өглөг	3,464,292.31	1,083,662.01
Ажилчидтай холбогдсон тооцоо		
Цалингийн өглөг		
НДШ-ийн өглөг		1,083,662.01
ХАОАТ-ын өглөг	3,464,292.31	
Урьдчилж орсон орлого		
Төсөвт байгууллага		
Урьдчилж орсон хөрөнгийн орлого		
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,464,292.31	1,083,662.01
Урт хугацаат зээл	-	-
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР		
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,464,292.31	1,083,662.01
Засгийн газрын хувь оролцоо		
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	3,560,849,767.86	3,560,849,767.86
Хуримтлагдсан үр дүн	1,346,098,679.72	4,149,679,818.36
Өмнөх үеийн үр дүн	1,186,388,414.01	1,186,388,414.01
Тайлант үеийн үр дүн		2,963,291,404.35
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,659,043.47	21,659,043.47
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	4,928,607,491.05	7,732,188,629.69
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	4,932,071,783.36	7,733,272,291.70

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	14,737,522,769.87	22,615,709,761.42
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,503,980,272.34	22,406,591,896.42
Улсын төсвийн санхүүжилт	14,354,380,272.34	18,546,205,720.00
Урсгал төсвийн санхүүжилт	13,957,723,902.34	18,546,205,720.00
Хөрөнгө оруулалтын санхүүжилт	396,656,370.00	-
Орон нутгийн төсвөөс	-	-
Бусад төсөвт байгууллагаас	-	-
Нийгмийн даатгалыг сангаас	-	-
Бусад тусгай зориулалтын сангаас	-	129,624,000.00
Тусламжийн орлого	149,600,000.00	3,730,762,176.42
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	233,542,497.53	209,117,865.00
Өмчийн орлого	-	-
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	233,542,497.53	209,117,865.00
Торгууль, төлбөрийн орлого	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	14,737,522,769.87	22,615,709,761.42
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	14,907,827,606.19	19,609,135,087.07
АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	7,797,255,884.10	8,069,022,218.71
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	7,035,665,853.61	7,203,305,824.74
Цалин	6,702,420,453.61	6,854,841,624.74
Хоол, унааны хөнгөлөлт	333,245,400.00	348,464,200.00
Бусад	-	-
Нийгмийн хамгааллын шимтгэл	761,590,030.49	865,716,393.97
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэлүүд	761,590,030.49	436,704,302.81
Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	429,012,091.16
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	7,110,571,722.09	11,540,112,868.36
Тогтмол зардал	-	-
Гэрэл цахилгааны зардал	-	-
Түлш, халаалтын зардал	-	-
Цэвэр, бохир усны зардал	-	-
Үйл ажиллагааны зардал	-	-
Хоол	-	-
Эм	-	-
Бусад бараа үйлчилгээний зардал	7,110,571,722.09	11,540,112,868.36
Бичиг хэргийн материал	106,825,985.99	118,964,401.93
Тээвэр, шатахууны зардал	541,238,548.00	600,396,241.40
Шуудан холбооны зардал	278,504,098.17	207,544,224.70
Дотоод томилолтын зардал	754,945,685.19	4,686,229,932.00
Гадаад томилолтын зардал	445,852,333.63	215,193,065.68
Ном, хэвлэлийн зардал	67,421,662.00	237,765,611.35
Хичээл, сургалт үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	-
Сургалт семинарын зардал	347,647,924.20	185,586,148.00
Эрдэм шинжилгээний ажлын зардал	-	41,601,397.20
Жижиг эд хогшил худалдан авах зардал	13,039,478.65	4,352,655.14
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	-	-
Төлбөр, хураамж, жижиг татаварууд зардал	41,118,312.78	159,827,396.02
Шагнал урамшууллын зардал	-	-
Баяр наадмын зардал	-	-
Төлбөр хураамж амь даатгал	22,800,000.00	22,469,160.60
Маягт хэвлүүлэх зардал	-	-

Урсгал засварын зардал	74,970,470.92	158,892,371.42
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал	14,708,970.00	17,080,000.00
Гадаадын зочны зардал	389,845,147.84	517,626,690.00
Бусад зардал	5,000,000.00	-
Мэдээлэл сурталчилгааны зардал	2,692,278,836.94	2,358,928,475.36
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	-	275,018,018.00
Элэгдлийн зардал	841,912,375.05	1,093,082,252.05
Ээлжийн амралтаараа орон нутаг явахад ОНО	-	811,900.00
Хуульд заасан үндэслэлээр ОНО	30,000,000.00	36,164,090.10
Олон улсын байгууллагын гишүүний татвар	30,727,580.00	25,761,400.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	205,153,877.00	125,161,379.86
Төсөвт төвлөрүүлсэн мөнгө	-	82,032,057.55
Өмнөх оны төсвийн хэмнэлт	206,580,435.73	129,624,000.00
Орон сууцны дэмжлэг	-	240,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	14,907,827,606.19	19,609,135,087.07
ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ ҮР ДҮН	(170,304,836.32)	3,006,574,674.35
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	-
Гадаад валютийн ханшийн зөрүүгийн олз \бодит\	-	-
Үндсэн хөрөнгө худалдсаны олз	4,598,626.98	6,510,950.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	4,598,626.98	6,510,950.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	49,794,220.00
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз \бодит\	-	-
Хөрөнгө худалдсаны гарз	-	49,794,220.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	49,794,220.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(165,706,209.34)	2,963,291,404.35

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,465,232,927.53	18,726,771,325.95
Улсын төсвөөс	15,231,543,430.00	18,546,205,720.00
Урсгал төсвийн санхүүжилт	14,654,486,460.00	18,546,205,720.00
Хөрөнгө оруулалтын санхүүжилт	370,476,370.00	-
Орон нутгийн төсвөөс	-	-
Бусад төсөвт байгууллагаас	206,580,600.00	-
Нийгмийн даатгалын сангаас	-	-
Бусад тусгай зориулалттай сангаас	-	-
Тусламжийн орлого	-	-
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	233,689,497.53	180,565,605.95
Өмчийн орлого	-	-
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	233,542,497.53	50,941,605.95
Торгууль, Төлбөрийн орлого	-	-
Бусад орлого	147,000.00	129,624,000.00
ҮЙЛ АЖИЛЛААГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	15,465,232,927.53	18,726,771,325.95
АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	7,816,321,307.35	8,069,022,218.71
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	7,035,665,853.61	7,203,305,824.74
Цалин	6,702,420,453.61	6,854,841,624.74
Цалингийн тусгай нэмэгдлүүд	-	-
Хоол, унааны хөнгөлөлт	333,245,400.00	348,464,200.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	780,655,453.74	865,716,393.97
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	-	-
Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	-
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	7,278,425,085.91	10,657,759,271.51
Тогтмол зардал	-	-
Гэрэл цахилгааны зардал	-	-
Түлш, халаалтын зардал	-	-
Цэвэр, бохир усны зардал	-	-
Үйл ажиллагааны зардал	-	-
Хоол	-	-
Эм	-	-
Бусад бараа үйлчилгээний зардал	7,278,425,085.91	10,657,759,271.51
Бичиг хэргийн зардал	105,300,540.00	147,142,510.00
Тээвэр, шатахууны зардал	541,238,548.00	600,396,241.40
Шуудан холбооны зардал	278,504,098.17	289,347,205.75
Дотоод томилолтын зардал	754,945,685.19	4,686,229,932.00
Гадаад томилолтын зардал	445,852,333.63	215,193,065.68
Ном, хэвлэлийн зардал	76,554,810.00	237,765,611.95
Хичээл, сургал үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	-
Сургалт семинарын зардал	347,647,924.20	185,586,148.00
Эрдэм шинжилгээний ажлын зардал	-	41,601,397.20
Жижиг эд хогшил худалдан авах зардал	128,559,822.60	177,310,462.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худ. авах зардал	-	-
Төлбөр, хураамж, жижиг татварууд	135,231,799.08	159,827,396.02
Өмнөх оны төсвийн хэмнэлт	206,580,435.73	129,624,000.00
Банкны үйлчилгээний хураамж	-	-
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлч. төлбөр	2,622,847,132.81	2,358,928,475.36
Маягт хэвлүүлэх зардал	-	-
Урсгал засварын зардал	38,436,224.00	105,774,442.80
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал	14,708,970.00	17,080,000.00

Гадаад зочны зардал	389,845,147.84	517,626,690.00
Төлбөр хураамж амь даатгал	22,800,000.00	22,469,160.60
Байрны түрээсийн зардал	-	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	-	275,018,018.00
Төсөл арга хэмжээний зардал цагийн хөлс	-	-
Гарсан зардлаа дансны нэгдсэн жагсаалтаас авах	-	-
Төвлөрүүлэн шилжүүлэх	903,490,157.66	81,826,057.55
Урьд оны өр	-	-
Ээлжийн амралтаараа орон нутагт явахад ОНО	-	811,900.00
Олон улсын байгууллагын гишүүний татвар	30,727,580.00	25,761,400.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	205,153,877.00	106,275,067.10
Орон сууцны дэмжлэг	-	240,000,000.00
Хуульд заасан үндэслэлээр ОНОлговор	30,000,000.00	36,164,090.10
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	15,094,746,393.26	18,726,781,490.22
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	370,486,534.27	(10,164.27)
Хөрөнгийн орлого	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусад хөрөнгө борлуулсны орлого	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	396,656,370.00	-
Хөрөнгийн бусад зардал	-	-
Гарсан зардлаа дансны нэгдсэн жагсаалтаас авах	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)	396,656,370.00	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН	(396,656,370.00)	-
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	-	-
Авсан зээл	-	-
Төлсөн зээл	-	-
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(26,169,835.73)	(10,164.27)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,180,000.00	10,164.27
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,164.27	-

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН
2012 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,560,849,767.86	21,659,043.47	1,511,804,889.06	5,098,912,327.37
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	(4,598,626.98)			(4,598,626.98)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			(165,706,209.34)	(165,706,209.34)
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,560,849,767.86	21,659,043.47	1,346,098,679.72	4,928,607,491.05
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(159,710,265.71)	(159,710,265.71)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,560,849,767.86	21,659,043.47	1,186,388,414.01	4,768,897,225.34
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			2,963,291,404.35	2,963,291,404.35
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,560,849,767.86	21,659,043.47	4,149,679,818.36	7,732,188,629.69

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

Төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨСӨВ	ТАЙЛАНТ ОН	ЗӨРҮҮ	ХУВЬ
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	23,418,824,800.00	18,515,331,432.67	(4,903,493,367.33)	79.1
УРСГАЛ ЗАРДАЛ	22,918,824,800.00	18,515,331,432.67	(4,903,493,367.33)	80.8
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,918,824,800.00	18,515,331,432.67	(4,403,493,367.33)	80.8
Бүлгийн дүнгээр хянагддаг зардлууд			-	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,996,385,500.00	7,203,305,824.74	(793,079,675.26)	90.1
Үндсэн цалин	7,573,301,900.00	6,854,841,624.74	718,460,275.26	90.5
Унаа хоолны хөнгөлөлт	423,083,600.00	348,464,200.00	74,619,400.00	
Урамшуулал			-	
Гэрээт ажлын цалин			-	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	900,606,500.00	865,716,393.97	34,890,106.03	96.1
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	900,606,500.00	865,716,393.97	34,890,106.03	96.1
Тэтгэмжийн даатгал			-	
ҮОМШӨ-ийн даатгал			-	
Ажилгүйдлийн даатгал			-	
Эрүүл мэндийн даатгал			-	
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-	-	-
Гэрэл цахилгаан			-	
Түлш халаалт			-	
Цэвэр бохир ус			-	
Байрны түрээс			-	
Хангамж, бараа материалын зардал	1,896,256,000.00	1,451,962,031.10	444,293,968.90	76.6
Бичиг хэрэг	136,210,000.00	147,142,510.00	(10,932,510.00)	108.0
Тээвэр шатахуун	812,524,200.00	600,396,241.40	212,127,958.60	73.9
Шуудан холбоо интернэтийн төлбөр	422,845,000.00	289,347,205.75	133,497,794.25	68.4
Ном хэвлэл	340,707,500.00	237,765,611.95	102,941,888.05	69.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал			-	
Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	183,969,300.00	177,310,462.00	6,658,838.00	96.4
Нормативт зардал	-	-	-	-
Эм, бэлдмэд, эмнэлгийн хэрэгсэл			-	
Хоол, хүнс			-	
Нормын хувцас зөөлөн эдлэл			-	
Эд хогшил, урсгал засварын зардал	118,500,000.00	105,774,442.80	12,725,557.20	89.3
Багаж техник хэрэгсэл			-	
Тавилга			-	
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл			-	
Урсгал засвар	118,500,000.00	105,774,442.80	12,725,557.20	89.3
Томилолт, зочны зардал	7,003,993,700.00	5,419,049,687.68	1,584,944,012.32	77.4
Дотоод албан томилолт	5,615,218,400.00	4,686,229,932.00	928,988,468.00	83.5
Гадаад албан томилолт	785,000,000.00	215,193,065.68	569,806,934.32	27.4
Зочин хүлээн авах зардал	603,775,300.00	517,626,690.00	86,148,610.00	85.7
Зардлын зүйл тус бүрээр хянагдах тогтмол зардлууд	3,726,020,700.00	2,582,826,429.18	1,143,194,270.82	69.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж			-	
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох			-	
Даатгалын үйлчилгээ	84,500,000.00	22,469,160.60	62,030,839.40	26.6
Мэдээлэл сурталчилгааны зардал	3,318,132,600.00	2,358,928,475.36	959,204,124.64	71.1
Эрдэм шинжилгээний ажил	120,000,000.00	41,601,397.20	78,398,602.80	34.7

Тээврийн хэрэгслийн татвар				-	
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж				-	
Газрын төлбөр				-	
Улсын мэдээллийн маягт хэвлэж бэлтгэх				-	
Төлбөр хураамж болон бусад зардал	203,388,100.00	159,827,396.02	43,560,703.98	78.6	
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ				-	
Мэдээлэл технологийн үйлчилгээ				-	
Холбооны суваг ашигласны хөлс				-	
Харуул хамгаалалтын зардал				-	
Бараа үйлчилгээний бусад зардал	475,815,000.00	202,666,148.00	273,148,852.00	42.6	
Төсвийн урамшуулал				-	
Эрсдлийн сангийн нөөц				-	
нэг иргэнд нормвативаар тооцсон нөөц				-	
Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх				-	
Ой тэмдэглэх зардал				-	
Урьд оны өр				-	
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	434,815,000.00	185,586,148.00	249,228,852.00	42.7	
Биеийн тамир тэмцээн уралдаан	41,000,000.00	17,080,000.00	23,920,000.00	41.7	
Засгийн газрын нөөц хөрөнгө				-	
Орон нутгийн нөөц хөрөнгө				-	
Төвлөрсөн арга хэмжээ				-	
Төрийн байгууллага, ажилтаны буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлын нөхөн төлбөр				-	
Хөтөлбөр болон төслийн дотоод урсгал				-	
Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	768,079,800.00	658,269,075.20	109,810,724.80	85.7	
Төрийн албан хаагчдын гэр бүлд олгох дэмжлэг				-	
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	2,575,000.00	811,900.00	1,763,100.00		
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	319,840,800.00	275,018,018.00	44,822,782.00	86.0	
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг				-	
Орон байраар хангах, орон сууцны дэмжлэг /хувь хүн/	240,000,000.00	240,000,000.00		-	100.0
Эмчилгээний төлбөр				-	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	105,664,000.00	106,275,067.10	(611,067.10)	100.6	
Нүүлгэн шилжүүлэх зарчим				-	
Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж				-	
Хуульд заасан үндэслэлээр албан хаагчид олгох нөхөн олговор	100,000,000.00	36,164,090.10	63,835,909.90	36.2	
Засгийн газрын гадаад шилжүүлэг				-	
Гадаад болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	33,167,600.00	25,761,400.00	7,406,200.00	77.7	
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	500,000,000.00	-	(500,000,000.00)	-	
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	500,000,000.00	-	(500,000,000.00)	-	
Төсвийн хөрөнгөөр санхүүжих ХО барилга байгууламж	500,000,000.00		(500,000,000.00)	-	
Төсвийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж				-	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,418,824,800.00	18,515,321,268.40	4,903,503,531.60	79.1	
Төсвөөс олгосон санхүүжилт	22,918,824,800.00	18,515,321,268.40	4,403,503,531.60	80.8	
Үндсэн үйл ажиллагааны орлого				-	

Туслах үйл ажиллагааны орлого			-	
ХО-н санхүүжилт	500,000,000.00	-	500,000,000.00	-
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		10,164.27		
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-		
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
АЖИЛЛАГСАД БИГД	627	607	20	96.8
Удирдах ажилтан	81	67	14	82.7
Гүйцэтгэх ажилтан	520	514	6	98.8
Үйлчлэх ажилтан	26	26	-	100.0
Гэрээт ажилтан	-	-	-	